

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2023/125/НА- СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор хот

2023 оны 02 дугаар сарын 24-ний өдөр

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын

Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер А.Цээням

Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Должмаа

Утас: 88110538 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3 . САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5.1 Төлбөрийн акт	17
5.2 Албан шаардлага	17
5.3 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2023.02.24 № 2/100

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2022 онд 71802 хөтөлбөрийн 11 арга хэмжээний зардалд 1,188,805.8 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 1,098,462.9 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсвийн хэмнэлтийн 5,605.9 мянган төгрөгийг оны эцэст төсөвт төвлөрүүлж, харилцах дансанд 84,736.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Аудитын гол асуудал

БШУЯ-ны байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээгээр “А” үнэлгээ авч, хоёрдугаар түвшинд үнэлэгдэж, 30,000.0 мянган төгрөгийн урамшуулал авсныг албан хаагчдад урамшуулал олгох, хөрөнгө худалдан авахад зарцуулсан, үр дүнд суурилсан гүйцэтгэлийн үнэлгээгээр 11 багш 2-4 дүгээр түвшинд үнэлэгдсэн байна.

“Боловсролын мэдээллийн технологийн төв” УТҮГ-аас суурилуулсан интернэтийг ашиглах, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын бүрдлийг

сайжруулах, холбогдох шийдвэрийн дагуу албан хаагчдын цалин хөлсийг үнэн зөв тооцох зэрэг зөвлөмжийг өгсөн, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, гүйцэтгэлийн үнэлгээгээр хангалттай түвшнээр үнэлэгдээгүй сургуулийн 6 багшид 1 ур чадварын нэмэгдэл олгосон зөрчилд албан шаардлага өгсөн нь бидний тогтоосон материаллаг байдлаас хэтрээгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээх бөгөөд Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 11 зорилтын 49 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг сумын Засаг дарга, Баянхонгор аймгийн БШУГ-аас 97.5 хувиар үнэлсэн байна.

Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>111,706,180.10</u>	<u>189,304,856.13</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	85,036,993.12
312	Банканд байгаа бэлэн мөнгө	00.00	85,036,993.12
3121	Төгрөг	00.00	85,036,993.12
31211	Төрийн сангийн харилцах	00.00	85,036,993.12
33	АВЛАГА	7,362,997.09	1,660,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	7,362,997.09	1,660,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	104,343,183.01	102,607,863.01
351	Түүхий эд материал	14,149,561.40	17,443,454.40
35110	Тусгай зориулалттай материал	14,149,561.40	17,443,454.40
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	25,000,000.00	25,000,000.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	189,650.00	25,100.00
354	Хангамжийн материал	65,003,971.61	60,139,308.61
35410	Бичиг хэргийн материал	1,937,900.00	1,018,260.00
35420	Аж ахуйн материал	40,016,954.61	42,931,569.61
35450	Барилгын засварын материал	11,951,000.00	10,000,000.00
35460	Хүнсний материал	7,895.00	81,530.00
35470	Бусад хангамжийн материал	11,090,222.00	6,107,949.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,299,546,698.87</u>	<u>1,295,361,718.04</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,299,546,698.87	1,295,361,718.04
392	Биет хөрөнгө	1,282,050,698.87	1,268,985,718.04
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,183,417,394.47	1,183,417,394.47
39202	Хуримтлагдсан элэгдэл	-88,854,332.08	-116,239,922.98
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	209,755,633.07	261,081,873.07
39206	Хуримтлагдсан элэгдэл	-141,920,203.19	-161,282,452.19
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	150,425,515.11	150,425,515.11
39208	Хуримтлагдсан элэгдэл	-81,365,199.22	-95,553,353.39
39214	Бусад үндсэн хөрөнгө	38,735,903.98	38,735,903.98
39215	Хуримтлагдсан элэгдэл	-11,743,650.48	-15,413,877.24
39217	Ном	23,599,637.21	23,814,637.21
393	Биет бус хөрөнгө	17,496,000.00	26,376,000.00
39301	Программ хангамж	450,000.00	450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-450,000.00	-450,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	17,496,000.00	26,376,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,411,252,878.97</u>	<u>1,484,666,574.17</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>562,156.00</u>	<u>377,000.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	562,156.00	377,000.00
413	Өглөг	562,156.00	377,000.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	535,156.00	377,000.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	27,000.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,410,690,722.97</u>	<u>1,484,289,574.17</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,410,690,722.97	1,484,289,574.17
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	319,214,873.32	319,214,873.32
51101	Өмч: - төрийн	319,214,873.32	319,214,873.32
512	Хуримтлагдсан үр дүн	190,639,238.93	264,238,090.13
51210	Өмнөх үеийн үр дүн	213,250,097.40	189,729,151.04
51220	Тайлант үеийн үр дүн	-22,610,858.47	74,508,939.09
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	900,836,610.72	900,836,610.72
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,411,252,878.97</u>	<u>1,484,666,574.17</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	975,247,634.40	1,236,186,893.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	24,474,571.40	47,381,093.00
120	Нийтлэг татварын бус орлого	24,474,571.40	47,381,093.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	24,474,571.40	3,073,600.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		3,073,600.00
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	16,770,000.00	
120012	Эрхийн шимтгэлийн орлого /ТӨҮГ/	7,704,571.40	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	950,773,063.00	1,188,805,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	825,998,700.00	1,039,466,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	1,039,466,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	825,998,700.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	28,035,733.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	28,035,733.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	96,738,630.00	149,339,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	96,738,630.00	149,339,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	992,918,492.87	1,161,677,953.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	992,918,492.87	1,161,677,953.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	912,465,593.07	1,075,155,500.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	591,292,251.22	731,776,312.27
210101	Үндсэн цалин	591,292,251.22	516,174,046.33
210102	Нэмэгдэл	00.00	162,081,472.94
210104	Урамшуулал	00.00	17,515,967.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	36,004,826.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	75,851,014.89	81,502,482.81
210201	Тэтгэврийн даатгал	51,010,139.00	63,431,882.20
210202	Тэтгэмжийн даатгал	6,837,212.89	4,060,889.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,801,048.00	3,761,020.95
210204	Ажилгүйдлийн даатгал	1,200,233.00	931,698.66
210205	Эрүүл мэндийн даатгал	12,002,382.00	9,316,991.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	95,738,630.00	101,803,130.00
210301	Гэрэл, цахилгаан	3,736,570.00	4,767,530.00
210302	Түлш, халаалт	90,902,060.00	96,485,600.00
210303	Цэвэр, бохир ус	1,100,000.00	550,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	46,913,852.71	24,418,135.00
210401	Бичиг хэрэг	5,344,163.00	13,614,240.00
210402	Тээвэр, шатахуун	2,100,000.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,218,600.00	2,750,000.00
210404	Ном, хэвлэл	200,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	690,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,243,250.00	5,811,515.00
210408	Бараа материал акталсны зардал	32,117,839.71	2,242,380.00
2105	Нормативт зардал	28,079,940.00	52,006,120.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	30,100.00	00.00
210502	Хоол, хүнс	23,087,900.00	47,409,375.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,961,940.00	4,596,745.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,615,000.00	2,166,000.00
210604	Урсгал засвар	1,615,000.00	2,166,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,108,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	1,108,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	800,800.00	6,137,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300,800.00	2,220,100.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	500,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	3,417,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	71,066,104.25	75,346,220.83
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	10,740,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	71,066,104.25	64,606,220.83
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	80,452,899.80	86,522,453.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	48,041,340.00	80,916,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	23,537,400.00	61,396,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	23,977,940.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	526,000.00	19,520,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	5,605,953.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	5,605,953.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	32,411,559.80	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	32,411,559.80	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-17,670,858.47	74,508,939.09
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4,940,000.00	00.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	4,940,000.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-4,940,000.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-22,610,858.47	74,508,939.09

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	953,512,379.00	1,185,563,447.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,739,316.00	2,363,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,739,316.00	2,363,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,739,316.00	2,363,600.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,739,316.00	2,363,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	950,773,063.00	1,185,563,447.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	825,998,700.00	1,039,466,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	1,039,466,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	825,998,700.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	28,035,733.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	28,035,733.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	96,738,630.00	149,339,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	96,738,630.00	149,339,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	909,121,379.00	1,100,526,453.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	909,121,379.00	1,100,526,453.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	828,476,529.20	1,020,874,503.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	605,656,135.21	726,796,709.50
210101	Үндсэн цалин	410,690,774.00	501,623,215.50
210102	Нэмэгдэл	150,371,923.21	167,852,701.00
210104	Урамшуулал	44,593,438.00	17,515,967.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	39,804,826.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	69,887,875.99	81,514,332.38
210201	Тэтгэврийн даатгал	52,305,492.31	62,799,145.02
210202	Тэтгэмжийн даатгал	5,164,332.11	4,705,476.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,142,876.92	3,761,020.95

210204	Ажилгүйдлийн даатгал	752,324.01	931,698.66
210205	Эрүүл мэндийн даатгал	7,522,850.64	9,316,991.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	95,738,630.00	101,803,130.00
210301	Гэрэл, цахилгаан	3,736,570.00	4,767,530.00
210302	Түлш, халаалт	90,902,060.00	96,485,600.00
210303	Цэвэр, бохир ус	1,100,000.00	550,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,318,300.00	00.00
210401	Бичиг хэрэг	1,347,800.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	2,100,000.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,719,500.00	00.00
210404	Ном, хэвлэл	300,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,471,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,380,000.00	00.00
2105	Нормативт зардал	28,060,295.00	58,720,130.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,494,100.00	00.00
210502	Хоол, хүнс	23,095,795.00	58,720,130.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,470,400.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,459,800.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	3,459,800.00	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	580,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	580,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,246,993.00	9,348,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,508,993.00	1,941,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	238,000.00	7,406,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,528,500.00	31,224,682.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,000,000.00	20,610,882.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,528,500.00	10,613,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	80,644,849.80	75,120,783.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	48,233,290.00	69,514,830.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	23,553,350.00	49,994,830.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	23,977,940.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	702,000.00	19,520,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	5,605,953.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	5,605,953.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	32,411,559.80	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	32,411,559.80	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	44,391,000.00	105,641,633.12
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	44,391,000.00	20,604,640.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	44,391,000.00	20,604,640.00
2200	Дотоод эх үүсвэрээр	44,391,000.00	20,604,640.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	44,391,000.00	20,604,640.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-44,391,000.00	-20,604,640.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	85,036,993.12
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	85,036,993.12

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	319,214,873.32	900,836,610.72	189,729,151.04	1,409,780,635.08
D01	2022 оны 1-р сарын 31-нээрх үлдэгдэл	319,214,873.32	900,836,610.72	189,729,151.04	1,409,780,635.08
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	319,214,873.32	900,836,610.72	189,729,151.04	1,409,780,635.08
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	74,508,939.09	74,508,939.09
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	319,214,873.32	900,836,610.72	264,238,090.13	1,484,289,574.17

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,193,110,900.00	1,100,526,453.88	92,584,446.12	92.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,193,110,900.00	1,100,526,453.88	92,584,446.12	92.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,108,800,800.00	1,020,874,503.88	87,926,296.12	92.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	779,794,500.00	726,796,709.50	52,997,790.50	93.2
210101	Үндсэн цалин	554,254,200.00	501,623,215.50	52,630,984.50	90.5
210102	Нэмэгдэл	166,868,200.00	167,852,701.00	(984,501.00)	100.6
210104	Урамшуулал	17,499,700.00	17,515,967.00	(16,267.00)	100.1
210105	Гэрээт ажлын хөлс	41,172,400.00	39,804,826.00	1,367,574.00	96.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	77,555,200.00	81,514,332.38	(3,959,132.38)	105.1
210201	Тэтгэврийн даатгал	62,282,400.00	62,799,145.02	(516,745.02)	100.8
210202	Тэтгэмжийн даатгал	7,797,900.00	4,705,476.16	3,092,423.84	60.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,238,300.00	3,761,020.96	2,477,279.04	60.3
210204	Ажилгүйдлийн даатгал	1,559,500.00	931,698.66	627,801.34	59.7
210205	Эрүүл мэндийн даатгал	15,595,500.00	9,316,991.58	6,278,508.42	59.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	102,020,500.00	101,803,130.00	217,370.00	99.8

210301	Гэрэл, цахилгаан	4,142,300.00	4,767,530.00	(625,230.00)	115.1
210302	Түлш, халаалт	96,778,200.00	96,485,600.00	292,600.00	99.7
210303	Цэвэр, бохир ус	1,100,000.00	550,000.00	550,000.00	50.0
2105	Нормативт зардал	57,066,500.00	48,583,010.00	8,483,490.00	85.1
210502	Хоол, хүнс	57,066,500.00	48,583,010.00	8,483,490.00	85.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	1,000,000.00	(1,000,000.00)	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,453,000.00	9,348,000.00	2,105,000.00	81.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,945,100.00	1,941,500.00	2,003,600.00	49.2
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,507,900.00	7,406,500.00	101,400.00	98.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	59992400.00	51829322.00	8,163,078.00	86.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	48,730,500.00	41,215,522.00	7,514,978.00	84.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,261,900.00	10,613,800.00	648,100.00	94.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	84310100.00	69514830.00	14,795,270.00	82.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	84,310,100.00	69,514,830.00	14,795,270.00	82.5
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	64,789,400.00	49,994,830.00	14,794,570.00	77.2
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,520,700.00	19,520,000.00	700.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,193,110,900.00	1,185,563,447.00	7,547,453.00	99.4
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	149,339,300.00	143,733,347.00	5,605,953.00	96.2
132001	Орон нутгийн төсвөөс	149,339,300.00	143,733,347.00	5,605,953.00	96.2
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,305,100.00	2,363,600.00	1,941,500.00	54.9
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,305,100.00	2,363,600.00	1,941,500.00	54.9
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	85,036,993.12	(85,036,993.12)	
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	49.00	49.00	-	
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	-	
620002	Гүйцэтгэх ажилтан	36.00	36.00	-	
620003	Үйлчлэх ажилтан	12.00	12.00	-	
620004	Гэрээт ажилтан	00.00	00.00	-	
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	49.00	49.00	-	
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	30.00	30.00	-	
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	19.00	19.00	-	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянговь сумын Ерөнхий боловсролын сургууль нь "Суралцах чадвартай, бичгийн соёл, зөв дадал хэвшилтэй бүтээлч хүүхдийг төлөвшүүлэх" эрхэм зорилготой тус байгууллага нь Боловсрол, шинжлэх ухааны яамнаас жил бүр дэвшүүлэн тавьсан зорилго зорилтыг хангах үүднээс байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах чиг үүргийн дагуу Захиргаа аж ахуй, Нийгмийн ухаан, Байгалийн ухаан, Бага ангийн заах аргын нэгдэл гэсэн бүтэц зохион байгуулалттай 49 орон тоотой, 498 суралцагчтай үйл ажиллагаа явуулсан байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг сургуулийн захирал Ц.Буянтогтох, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Ж.Золжаргал нар зурж, нярваар Д.Ууганчимэг нар ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Бага, дунд боловсролын тухай, Боловсролын тухай, Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгууллагын нууцын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Гамшгаас хамгаалах тухай, Зөрчлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Тайлант онд шинээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдсөн;
- Хөдөлмөрийн тухай хуулийг шинэчилснийг мөрдсөн;
- Засгийн газрын 2022 оны 107, 192 дугаар тогтоолоор цалингийн шатлал өөрчлөгдсөн;
- Засгийн газрын 2022 оны 120 дугаар тогтоолоор албан томилолын зардлын тариф өөрчлөгдсөн;
- Засгийн газрын 2022.03.02-ны өдрийн 91 дүгээр тогтоолоор хичээл сургалтын үйл ажиллагаа, багш ажиллагсдын тасралтгүй хөгжлийг дэмжих, мэдээллийн технологийн үйлчилгээний зардлыг тус тус хэрэгжүүлэн ажиллах ажлын хэсгийг томилсон;
- БШУС-ын 2022.05.12-ны өдрийн 170 дугаар тушаалын дагуу 3 ажлын хэсгийг байгуулсан.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй Баянхонгор аймгийн СТСХ-ээс бэлтгэж гаргасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 74,249.7 мянган төгрөгөөр буюу 5.3 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт А	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл 1	Эцсийн үлдэгдэл 2	Өөрчлөлт 3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	85,036.99	85,036.99
Авлага	6,526.97	1,660.00	(4,866.97)
Бараа материал	104,343.18	102,607.86	(1,735.32)
Үндсэн хөрөнгө	1,623,880.08	1,684,301.32	60,421.24
Хуримтлагдсан элэгдэл	(324,333.38)	(388,939.61)	(64,606.23)
Нийт хөрөнгө	1,410,416.85	1,484,666.57	74,249.73
Өр төлбөр	636.21	377.00	(259.21)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,409,780.63	1,484,289.57	74,508.94
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,410,416.84	1,484,666.57	74,249.73

Эх сурвалж: Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан дансанд нь мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгийн данс байна.

Батлагдсан төсвөөс эрүүл мэндийг дэмжих зардлаас 1,038.6 мянга, хүүхэд өдрийн гүйцэтгэлээс шалтгаалж үдийн хоол, дотуур байрны хүүхдийн хоолны зардал 13,140.9 мянга, математикийн багшийн орон тоо дутагдалтайгаас цалин, ажил олгогчоос олгох шимтгэлийн зардал 4,700.9 мянган төгрөгийн зардал хэмнэсэн, цахим дэлгүүрт захиалсан үндсэн хөрөнгө ирээгүйгээс хүүхдэд ээлтэй сургалтын орчин зардлаас 3,000.0 мянга, гүйцэтгэлийн үнэлгээгээр олгосон урамшууллаас 3,192.5 мянган төгрөгийг зарцуулаагүй зэргээс шалтгаалж, оны эцэст харилцах дансанд 85,036.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Оны эхний 6,526.9 мянган төгрөгийн авлагыг төрийн аудитын байгууллагаас төлбөрийн акт тогтоосныг бүрэн барагдуулсан, оны эцэст 1,660.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааны авлагатай гарсан ба авлагын 100.0 мянган төгрөг нь ажлаас халагдсан ажилтны, 1,560.0 мянган төгрөгийн авлага нь нягтлан бодогчтой холбоотой 2022 оны 11-12 сард авсан цалингийн урьдчилгаа ба тус авлагыг нягтлан бодогч 2022.12.30-ны өдөр төлж, байгууллагын харилцах дансанд 2023.01.01-ний өдөр орсон байна.

Төсвийн хөрөнгөөр тайлант онд 20,604.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, үнэ төлбөргүйгээр 215.0 мянган төгрөгийн ном, 1,050.0 мянган төгрөгийн өсгөгч, аймгийн БШУГ 27,285.6 мянган төгрөгийн зөөврийн компьютер, НҮБ-ийн Хүүхдийн сангийн хөрөнгө оруулалтаар 2,386.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө тайланд ирснээр үндсэн хөрөнгө нэмэгдсэн, сумын ИТХ-ын тогтоолоор биеийн тамирын талбайн 2000 м² талбайг бүртгэсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 74,508.9 мянган төгрөгөөр нэмэгдэж, 264,238.1 мянган төгрөг болсон байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү данс өөрчлөлтгүй, тайлант үеийн үр дүн 74,508.9 мянган төгрөгөөр нэмэгдэн 1,484,666.6 мянган төгрөг болсон байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,207,422.0 мянган төгрөгөөр төлөвлөж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас үйл ажиллагааны зардлыг 86,914.4 мянган төгрөгөөр хасаж, 1,120,507.6 мянган төгрөгөөр баталсан нь цалингийн зардлыг өндөр төлөвлөсөнтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны орон нутгийн төсвөөс олгохоор баталсан 149,339.3 мянган төгрөгийг тайлант хугацаанд өөрчлөөгүй байна, харин улсын төсвөөс олгохоор баталсан төсвийг дээд шатны байгууллагаас 2022 оны 4 дүгээр сард цалин, урамшуулал, үдийн цайны зардал 23,723.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн, 10 дугаар сард хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх зардалд 16,485.0 мянга, өөрийн орлогыг 1,941.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн нийт төсөв 1,013,317.8 мянган төгрөг болжээ. Оны эцэст 12 дугаар сард байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний урамшуулал 30,453.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, 2022 оны улсын төсвөөс олгох санхүүжилтийг 1,043,771.6 мянган төгрөгөөр баталж, 1,039,466.5 мянган төгрөгийг улсын төсвөөс авч, өөрийн орлогоор 4,305.1 мянган төгрөгийг оруулахаар баталжээ.

Тайлант онд тус байгууллага төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71802 (Ерөнхий боловсрол) хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс баталсан 1,039,466.5 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч, гүйцэтгэлээр 954,729.5 мянган төгрөгийг зарцуулж, хэмнэгдсэн 85,036.9 мянган төгрөг харилцах дансанд үлдэгдлээр зарцуулагдаагүй байна.

Орон нутгийн төсвөөс олгохоор баталсан 149,339.4 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, гүйцэтгэлээр батлагдсан санхүүжилтийн 96.3 хувь буюу 143,733.4 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст орон нутгийн төсвийн санхүүжилтийн харилцах дансны зарцуулаагүй үлдэгдэл 5,605.9 мянган төгрөгийн төсөвт төвлөрүүлжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80112-Нийтлэг үйлчилгээ	149,339.30	143,733.30	5,606.00	96.2
2	80826 Байр ашиглалтын үйлчилгээ	3,003.30	3,003.20	0.10	100.0
3	80312 Сургалт семинар	1,501.60	1,500.00	1.60	99.9
4	81605 Эрүүл мэндийг дэмжих	3,453.60	2,415.00	1,038.60	69.9
5	81801 үдийн цай хөтөлбөр	64,789.40	60,131.90	4,657.50	92.8
6	81806 Дотуур байрны үйлчилгээ	74,936.60	61,749.00	13,187.60	82.4
7	81816 Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	16,485.00	13,485.00	3,000.00	81.8
8	81823 Боловсролын байгууллагын багш	6,757.10	6,350.00	407.10	94.0
9	81834 Боловсролын стандарт, сургалт	747,156.50	683,621.80	63,534.70	91.5

10	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	121,383.50	115,068.10	6,315.40	94.8
11	81848 Сурах бичгийн түрээс	2,003.60	1,941.50	62.10	96.9
12	83602 ЗГ болон ЗД-ын нөөц хөрөнгөөс хуваарилсан	360.00	360.00	-	100.0

Эх сурвалж: Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн төсвийн хэлбэлзэл

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар сумын сайн малчин С.Эрдэнэбатаас хандивласан 360.0 мянган төгрөгийн орлого орсныг, байгууллагын орон нутгийн санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, зарцуулалгүй оны эцэст төсөвт төвлөрүүлсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн “Боловсролын мэдээллийн технологийн төв” УТҮГ-аас суурилуулсан интернэтийг ашиглах, анхан шатны баримтын бүрдлийг сайжруулах зэрэг зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цээням, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх тухай албан бичгийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023.01.03-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлж, санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг 2023.01.25-ны өдөр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант жилийн

батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн 1,193,110.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 17,896.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 12,527.7 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тайлант онд шатахуун, томилолтын зардлыг олгоогүй байна.

Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн тогтмол зардлын гүйцэтгэл өмнөх оноос 6,064.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь сургуулийн дотуур байр шинээр ашиглалтад орсонтой холбоотой халаалтын зардал 5,583.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн, гэрэл цахилгааны тариф нэмэгдсэнээс 1,030.9 мянган төгрөгөөр нэмэгдэж, цэвэр бохир усны зардал 550.0 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,051,458.5 мянган төгрөгийн 40 гүйлгээ, зарлагын 113,584.7 мянган төгрөгийн 13 гүйлгээ, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 21,269.5 мянган төгрөгийн 6 шийдвэр, 207,933.9 мянган төгрөгийн 3 худалдан авалтын мэдээллийг мэдээлсэн байна.

Харин тайлант онд аж ахуйн нэгж байгууллагуудтай байгуулсан 213,899.2 мянган төгрөгийн 9 гэрээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 108,868.2 мянган төгрөгийн 4 гүйлгээ, зарлагын 90,388.4 мянган төгрөгийн 9 гүйлгээ, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 7,195.5 мянган төгрөгийн 2 шийдвэрийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх онд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст гэрээг бүрэн байршуулах талаар менежментийн захидлаар зөвлөмж өгснийг хэрэгжүүлээгүйгээс зөрчлийг 2022 онд давтан гаргасан тул албан шаардлага өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагад 2022 оны 12 дугаар сард завсрын аудитыг гүйцэтгэж, асуудлын бүртгэлээр алдаа зөрчлийг танилцуулсан ба завсрын аудитын хэрэгжилтийг гаргуулан авч, хэрэгжилтийг дахин тооцсон болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж, 7,362.9 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, менежментийн захидлаар 13,823.6 мянган төгрөгийн 4 зөвлөмжийг байгууллагын удирдлагад хүргүүлсэн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	7,362.9	1	7,362.9	100%
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	4	13,823.6	4	13,823.6	50%
Нийт дүн	5	21,186.5	5	21,186.5	75%

Эх сурвалж: Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022.05.30-ны өдрийн 124 дүгээр албан бичиг

Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тус байгууллагаас 2022.06.20-ны өдөр 32 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна. Өмнөх аудитаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээ болон баримтлах чиглэлийн талаар Засгийн Газраас гаргасан тогтоол, журмуудыг хэрэгжүүлж, төсвийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах”, “Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг цаг хугацаанд нь мэдээлэх” зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд баригдсан сургуулийн гал тогооны барилгыг улсын комисс ашиглалтад хүлээн авч, актаар баталгаажсан боловч Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас шийдвэр ирээгүйгээс санхүүгийн тайланд бүртгээгүй байна.

Сургуулийн гал тогооны барилгыг ашиглаж байгаа ба 2021 онд халаалтын зардлыг төлөөгүй, 2022 онд халаалтын зардлыг батлуулж, 5,583.5 мянган төгрөгийг халаалтын зардалд төлсөн байна.

Мөн “Дэлхийн Зөн” олон улсын байгууллагын санхүүжилтээр 68,565.2 мянга, сургуулийн 2020 оны төсвөөс оролцооны хувийг тооцож 25,000.0 мянган төгрөг зарцуулж, нийт 93,565.2 мянган төгрөгийн үнэ бүхий ариун цэвэр эрүүл ахуйн байгууламжийг 2020 онд барьж дуусган, 2022.02.11-ний өдөр барилга байгууламж

ашиглалтад оруулах комиссын дүгнэлт гарсан боловч тус хөрөнгийг бүртгэх шийдвэр гараагүйгээс дуусаагүй барилга дансанд 25,000.0 мянган төгрөгөөр бүртгэсэн байна.

Сумын төвийн худгаас дээрх барилгуудад цэвэр усны шугам оруулах ажлыг 2020 онд “Чандмань Баянхонгор” ХК гүйцэтгэж, сургуулийн төсвөөс 10,000.0 мянган төгрөгийн зардал гарсныг барилгын засварын материал дансанд бүртгэлтэй байна.

Иймд дээрх хөрөнгүүдийг холбогдох газруудад хандан шийдвэрлүүлэх нь албан шаардлагыг өгсөн.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгээгүй болно.

Аудитаар нийт 2,155.5 мянган төгрөгийн 5 зөрчил¹ илэрснээс 398.8 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах 1,306.7 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 450.0 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Баянхонгор аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн даргын 2022.01.27-ны өдрийн 7/173 дугаар албан бичгээр нягтлан бодогч Ж.Золжаргалд ур чадварын нэмэгдэлд 2022 оны 1-6 дугаар сард 15 хувийн ур чадвар олгохоор заасныг үндэслэн сургуулийн захирлын 2022.03.24-ний өдрийн 08 дугаар тушаал гаргахдаа нэмэгдлийг 25 хувиар тооцож олгож, дээрх албан бичгийг хэрэгжүүлэлгүй, илүү цалин олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1.3 дахь “Цалин хөлсний хэмжээг тогтооход дараах зарчим баримтална: ажилтны ур чадварын түвшин, гүйцэтгэл, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулсан байх”, 107 дугаар зүйлийн “Ажил олгогч хуульд өөрөөр заагаагүй бол үндсэн цалинг ажлын байрны шинжилгээ, үнэлгээ, эсхүл ажилтны ур чадварт үндэслэн цагаар, хийснээр, бусад хэлбэрээр тооцно” гэснийг зөрчсөн тул нягтлан бодогчоор нөхөн төлүүлж, орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Баянговь сумын ЕБС-ийн захирлын 2022.12.21-ний өдрийн 61 дүгээр тушаалаар гүйцэтгэлийн үнэлгээгээр хангалттай түвшнээр үнэлэгдээгүй сургуулийн 6 багшид 1,306.7 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6 дахь “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд дараах арга хэмжээг авч ажиллана: байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох” гэснийг зөрчсөн тул төсвийн захирагчид зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

2. Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байгууллагын даргын 2022 онд гаргасан 7,195.5 мянган төгрөгийн 2 тушаал, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 108,868.2 мянган төгрөгийн орлогын 4, 90,388.4 мянган төгрөгийн зарлагын 9

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

гүйлгээ, аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулсан 213,899.2 мянган төгрөгийн 9 гэрээг байршуулаагүй, сар бүрийн санхүүжилтийн дүнг бөөн дүнгээр мэдээлсэн, мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална: Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална”, 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 дахь “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэснийг зөрчсөн байгаа тул зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан сургуулийн гал тогооны барилга, “Дэлхийн Зөн” олон улсын байгууллагын санхүүжилт, төсвийн хөрөнгөөр баригдсан ариун цэвэр эрүүл ахуйн байгууламжийг барьж дуусган, улсын комисс ашиглалтад хүлээн авсан байхад санхүүгийн тайланд хөрөнгөөр бүртгээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх “Төрийн өмчид эд хөрөнгийг дараах хэлбэрээр олж авна: хандив, тусламж, бэлэглэл, өвлөх журмаар олж авсан эд хөрөнгө”, 6.2 дахь “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэснийг зөрчсөн тул мэргэжлийн байгууллагаар хяналт хийлгэн хөрөнгөд орлого авах албан шаардлагыг өгөв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Интернетийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: БШУС-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх албанаас ирүүлсэн аудит хийх чиглэлийн 5-д "Боловсролын мэдээллийн технологийн төв" УТҮГ-аас бүх сургууль, цэцэрлэгийн интернэтийн төлбөрийг төлсөн, интернэтийн төлбөрийг давхардуулан төлж, үр ашиггүй зардал гаргасан байх" асуудлыг ирүүлснийг тодруулан шалгахад тус интернэтийн хурд, хүчин чадал шаардлага хангахгүйгээс ашиглах боломжгүй гэсэн шалтгаанаар 2022 онд үүрэн гэр интернэтийн төлбөрт 450.0 мянган төгрөгийг давхардуулан төлсөн байна.

Өгсөн зөвлөмж: “Боловсролын мэдээллийн технологийн төв” улсын төсвийн үйлдвэрийн газраас суурилуулсан интернэтийг бүрэн ашиглаж, бусад байгууллагуудад интернэтийн төлбөрийг давхардуулан төлөхгүй байх

2. Хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Албан хаагчдад цалингийн урьдчилгаа олгосон анхан шатны баримтын бүрдэл дутуу, төрийн сангийн төлөөлөгч гүйлгээний баримтад гарын үсэг зураагүй, он сар зөрүүтэй тэмдэглэсэн зөрчил завсрын аудитаар илэрсэн байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийг мөрдөж, анхан шатны баримтын бүрдэлд хяналт тавьж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан нягтлан бодогчид талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Баянхонгор аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн даргын 2022.01.27-ны өдрийн 7/173 дугаар албан бичгээр нягтлан бодогч Ж.Золжаргалд ур чадварын нэмэгдэлд 2022 оны 1-6 дугаар сард 15 хувийн ур чадвар олгохоор заасныг үндэслэн сургуулийн захирлын 2022.03.24-ний өдрийн 08 дугаар тушаал гаргахдаа нэмэгдлийг 25 хувиар тооцож олгож, дээрх албан бичгийг хэрэгжүүлэлгүй, илүү цалин олгосон байна.	1	398.8	1	398.8								
Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан сургуулийн гал тогооны барилга, "Дэлхийн Зөн" олон улсын байгууллагын санхүүжилт, төсвийн хөрөнгөөр баригдсан ариун цэвэр эрүүл ахуйн байгууламжийг барьж дуусган, улсын комисс ашиглалтад хүлээн авсан байхад санхүүгийн тайланд хөрөнгөөр бүртгээгүй байна.	1	0			0	0						

Албан хаагчдад цалингийн урьдчилгаа олгосон анхан шатны баримтын бүрдэл дутуу, төрийн сангийн төлөөлөгч гүйлгээний баримтад гарын үсэг зураагүй, он сар зөрүүтэй тэмдэглэсэн зөрчил завсрын аудитаар илэрсэн байна.	1	-					1	-				
БШУС-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх албанаас ирүүлсэн аудит хийх чиглэлийн 5-д "Боловсролын мэдээллийн технологийн төв" УТҮГ-аас бүх сургууль, цэцэрлэгийн интернэтийн төлбөрийг төлсөн, интернэтийн төлбөрийг давхардуулан төлж, үр ашиггүй зардал гаргасан байх" асуудлыг ирүүлснийг тодруулан шалгахад тус интернэтийн хурд, хүчин чадал шаардлага хангахгүйгээс ашиглах боломжгүй гэсэн шалтгаанаар 2022 онд үүрэн гэр интернэтийн төлбөрт 450.0 мянган төгрөгийг давхардуулан төлсөн байна.	1	450.0					1	450.0				
Дүн	4	848.8	1	398.8	1	0	2	450.0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байгууллагын даргын 2022 онд гаргасан 7,195.5 мянган төгрөгийн 2 тушаал, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 108,868.2 мянган төгрөгийн орлогын 4, 90,388.4 мянган төгрөгийн зарлагын 9 гүйлгээ, аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулсан 213,899.2 мянган төгрөгийн 9 гэрээг байршуулаагүй, сар бүрийн санхүүжилтийн дүнг бөөн дүнгээр мэдээлсэн, мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	0			1	0			
Дүн	1	0	0	0	1	0	0	0	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил /Төрийн хэмнэлтийн тухай хууль/									
Баянговь сумын ЕБС-ийн захирлын 2022.12.21-ний өдрийн 61 дүгээр тушаалаар гүйцэтгэлийн үнэлгээгээр хангалттай түвшнээр үнэлэгдээгүй сургуулийн 6 багшид 1,306.7 мянган төгрөгийн үр чадварын нэмэгдэл олгосон байна.	1	1306.7			1	1,306.7			
Дүн	1	1,306.7	1	-	1	1,306.7	0	0	
Нийт дүн	2	1,306.7	1	-	2	1,306.7	0	0	

---оОо---